



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ЗӨВЛӨМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
П.ДЭЛГЭРНАРАН ТАНАА

2017. 04. 05 № 02-01-001/86
танай _____ -ны № _____ -т

Үйл ажиллагаагаа сайжруулж
ажиллах тухай

Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/138 дугаартай тушаалаар баталсан “Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх заавар”-ын 1.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын “Автотээврийн тухай”, “Агаарын тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулиудын хэрэгжилт, холбогдох дүрэм, журам, улсын стандартад заасан шаардлагуудыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, автотээврийн хэрэгслийн техникийн байдал, хэрэглээний стандартын үзүүлэлтийг хангуулах, автотээврийн хэрэгслээс хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх, техникийн хяналтын үзлэгийн төвийн үйл ажиллагаа болон ажил үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж ажиллах үүднээс дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын “Автотээврийн тухай” хуулийн 19¹ дүгээр зүйлийн

-19¹.2.1 дэх заалтад заасны дагуу автотээврийн хэрэгслийн техникийн ашиглалтын байдалд тавих шаардлагын дагуу техникийн хяналтын үзлэгийг /автотээврийн хэрэгслийн ерөнхий байдал, иж бүрдэл, хөдөлгүүр, хүч дамжуулах анги, тоормосны систем, жолооны механизм, гэрэл дохио, явах анги, экологи болон эргономикийн үзүүлэлт/ бүрэн хийх;

-19¹.2.2 дахь заалтад заасны дагуу техникийн хяналтын үзлэгийн талаарх журам, стандартыг мөрдөх;

-19¹.2.3 дахь заалтад заасны дагуу үйлдвэрлэлийн байр, талбай, оношлогооны тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн стандартын үзүүлэлт, шаардлагыг хангаж, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаар жил бүр шалгуулж, баталгаажуулах;

001120502748

2. Монгол Улсын "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолын дагуу хийж буй байгууллагынхаа дотоод хяналт шалгалтын ажлыг сайжруулах, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах, ажлын тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдрийн дотор Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт ирүүлэх;

3. Монгол Улсын "Агаарын тухай" хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд автотээврийн хөдөлгүүрээс ялгарах утааны найрлага дахь хорт бодис болон утааны тортогжилтын хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн автотээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх /тээврийн хэрэгслийн гэрчилгээг хураан авч, Замын цагдаагийн газарт хүргүүлэх/, автотээврийн хэрэгслийн ашиглалтаас агаар орчинд хаягдаж байгаа агаар бохирдуулах бодисын хэмжээг багасгах, улмаар агаарын бохирдол, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулж, арилгахад автотээврийн хэрэгслийн ашиглалт, техникийн байдалд тавих хяналтыг хүчтэй болгох;

4. Зам, тээврийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 232 дугаартай тушаалаар баталсан "Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журам"-ын 2.4-д заасны дагуу тусгай зориулалтын автотээврийн хэрэгслийн /автокран/ ачаа өргөх төхөөрөмжийн техникийн байдлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар шалгаж, баталгаажуулсан дүгнэлтийг үндэслэн техникийн хяналтын үзлэгт хамруулах;

5. Дээрх журмын 1.2 /Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг аймгийн төв, нийслэлд техникийн хяналтын үзлэгийн суурин төвд, аймгийн төв, нийслэлээс алслагдсан нутаг дэвсгэрт техникийн хяналтын үзлэгийг явуулын төвөөр хийж гүйцэтгэнэ./-д заасны дагуу Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг явуулын төвөөр хийж гүйцэтгэхгүй байх;

6. Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 11 дүгээр 23-ны өдрийн 233 дугаартай тогтоолоор баталсан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам"-ын 101-д "Хэмжих хэрэгслийн тоног төхөөрөмжүүдийг ашиглах хугацаа-5 жил" гэж заасан байхад техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн хяналтын үзлэгийн хэмжих тоног төхөөрөмжүүд /тоормосны стэнд, тэнхлэг шалгагч, бензин хөдөлгүүртэй автомашины утааны найрлага хэмжигч, дизель хөдөлгүүртэй автомашины утааны тортогжилт хэмжигч, өргүүр, сувгийн өргүүр, дуу чимээ шалгагч, дөрөөний болон

жолооны сул явалт хэмжигч/ 13 жил ашиглагдаж байгаа бөгөөд тэдгээрийг шалгаж, баталгаажуулах итгэмжлэгдсэн лабораторийг ашиглалтанд оруулах арга хэмжээг нэн даруй авах;

7. Зам, тээврийн сайдын 2012 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 59 дугаартай тушаалаар баталсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын 3.5-д заасны дагуу автотээврийн хэрэгслийн хөдөлгүүр, арал, бүхээгийг өөрчилсөн тохиолдолд тухайн өөрчлөлт нь стандартын шаардлага хангаж байгааг нотолсон техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт, өмчлөгчийн хүсэлтийг үндэслэн өөрчлөлтийг хийх. Харин тээврийн хэрэгслийн зориулалтыг өөрчилсөн тохиолдолд зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ байхгүй тул энэ талаарх зөрчил хяналт шалгалтын явцад их илэрч байгаад анхаарч нэн даруй арга хэмжээ авах; /Тухайлбал, ачааны тэвш бүхий тээврийн хэрэгслүүдийн тэвшийг авч, ёмкост суурилуулсан, цемент тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслээр бохир ус зөөвөрлөж буй тээврийн хэрэгслүүд нь тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага, хэрэглээний стандартын үзүүлэлтийг хангаагүй, тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон бүх жингээс хэтрүүлэн ачаа тээвэрлэсэн, техникийн хувьд өнгө үзэмж муу, эдэлгээний баталгаат гүйлтийн нөөцгүй, найдварт ажиллагаа муудсан, зориулалтыг өөрчилсөн тээврийн хэрэгслүүдэд шинээр тээврийн хэрэгслийн гэрчилгээг олгосон зөрчлүүд илэрсэн болно.



-- Тээврийн хэрэгслийн техникийн зориулалтыг өөрчлөн бохир ус тээвэрлэж буй тээврийн хэрэгслүүд.




- Тээврийн хэрэгслүүд нь техникийн хувьд бүрэн бус, ачааны даацын хэмжээг хэтрүүлэн ачаа тээвэрлэсэн байдал./

8. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг хийхдээ "Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага" MNS5011:2003 улсын стандартын 5.1-д заасан үзүүлэлт, агрегат зангилаа, механизм, тоноглол, эд ангийг хамруулан шалгаж, техникийн хяналтын үзлэгийн технологийн картыг мөрдөж ажиллах;

9. "Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төв. Ангилал Ерөнхий шаардлага" MNS 5044:2010 улсын стандартын 7-д заасан "Хүний нөөцөд тавих шаардлага"-ыг бүрэн биелүүлж ажиллах;

10. Импортоор орж ирж буй автобусны арал дээрх автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар /VIN/-ын байдалд үзлэгийг сайтар хийж, хэрвээ ямар нэгэн зөрчилтэй байвал түүнийг эрх бүхий байгууллага /Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн/-аар шалгуулж, тогтоолгосны үндсэн дээр тээврийн хэрэгслийн гэрчилгээг олгох, зөвхөн автобусны дагаж ирсэн баримт бичгийг үндэслэн тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгохгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах, ажилтан, ажиллагсдын ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Энэхүү зөвлөмжид дурдсан үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэн ажилласан үр дүнг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус газарт албан бичгээр ирүүлэхийг мэдэгдье.

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Л.ЭРДЭНЭЧУЛУУН

ДЭД БҮТЦИЙН ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Н.ГАНТУЛГА

АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Ц.ХАДБААТАР